Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Тайлант хугацаанд албан хаагчаас 1, иргэнээс 1 нийт 2 гомдол, мэдээллийг хүлээн авсан ба Ёс зүйн дэд хорооны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдааны 01 дүгээр дүгнэлт, 06 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 2 дугаар дүгнэлтээр дээрх 2 албан хаагчийг ёс зүйн зөрчил гаргаагүй гэж дүгнэсэн. Энэ нь 2024 оны мөн үетэй харьцуулахад ёс зүйн зөрчлийн бууралт 100 хувь байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
Тайлант хугацаанд соён гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд "Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт" (50 секунд), "Төрийн албан хаагчид хориглох зүйл" (60 секунд), Авлигын хор хөнөөлийг таниулсан контент (1 минут 4 секунд)-ыг байгууллагын цахим хуудаст байршуулж олон нийтэд мэдээллээ. Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, чиг үүргийн онцлогийн хүрээнд авлигын эрсдэлээс анхид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалан 2 видео, 1 рийл, 1 гарын авлага, 8 постер бэлдэж, байгууллагын цахим хуудас, Гадаадын иргэн, харьяатын газрын олон нийтийн сүлжээний хаягаар олон нийтэд, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системээр албан хаагчдад мэдээлсэн. Гадаадын иргэн, харьяатын газар нь 2009 оны 06 дугаар сарын 03-ны өдөр ёс зүй, хариуцлагын талоны загвар, зохицуулалтыг анх баталсан бөгөөд тайлант хугацаанд холбогдох заалтыг зөрчсөн нийт 7 албан хаагчийн ёс зүй, хариуцлагын талонд сануулсан байна. Авлигын эсрэг хууль тогтоомжийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчийг албаны чиг үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан авлигад өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах зорилгоор "Авлига, ашиг сонирхлын нөлөөллийг мэдээлэх заавар"-ыг 10 дугаар сарын 01-ний өдрийн А/440 дүгээр тушаалаар, байгууллагын даргын 2025 оны "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай" 02 дугаар албан даалгаврыг тус тус баталлаа. Төрийн албаны ёс зүйн зөрчлийн бүртгэлийн системд 2025 онд байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны хэлэлцэж, шийдвэрлэсэн 2 асуудлыг бүртгэж, тайлагнасан. Мөн ХНУМТ цахим системд сахилгын шийтгэлтэй 19 албан хаагчийн мэдээллийг бүртгэсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн 2025 оны тайланг нэгтгэн боловсруулж, ГИХГ-ын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1643 дугаар албан бичгээр ХЗДХЯ-д хүргүүлсэн. Албан хаагчдын ёс зүйн тухай хууль тогтоомжийн мэдлэгийг шалгах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 03 болон 12 дугаар сард төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн нийт 197 албан хаагчийг хамруулласан. Албан хаагчдын ёс зүйн тухай хууль тогтоомжийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

нөлөөллийн аян"-ыг 1 сарын хугацаатай зохион байгуулж, 5 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүллээ.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд харьяалагдах удирдах албан тушаалтанд зориулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтад 01 дүгээр сарын 16-ны өдөр, Монгол Улсын Ёс зүйн хорооноос 12 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан "Ёс зүй ба хүний эрх" зорилтот богино хугацааны, үе шаттай сургалтад байгууллагын дарга Н.Уганбаяр хамрагдсан. "Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх тухай" 10 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр албан даалгаврыг баталж, нийт албан хаагчдыг хууль тогтоомжийг мөрдөх, аливаа дарамт, шахалт, нөлөөлөлд автахгүй, ёс зүйн зөрчилд өртөхгүй ажиллах чиглэлээр үүрэгжүүлэн төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн нийт 201 албан хаагчаар "Баталгааны хуудас" гаргуулсан. 2025 оны 12 дугаар сарын байдлаар Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн даргаар ажилласны урамшуулалд нийт 23,760,000 төгрөгийг олгосон байна.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 24-ний өдөр нийт 20 арга хэмжээтэй боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээлэл солилцох, ажлын уялдааг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, хамт олонд хүлээн зөвшөөрөгдсөн албан хаагчийг сонгож ирүүлэх тухай Ёс зүйн дэд хорооны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дугаартай дотоод албан бичгийг хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд хүргүүлсний дагуу нийт 6 газар, 1 хэлтсээс 7 албан хаагчийн нэр ирүүлсэн. Ирүүлсэн саналыг хэлэлцэн байгууллагын даргын 02 дугаар сарын 25-ны өдрийн А/106 дугаар тушаалаар дээрх 7 албан хаагчийг Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх албан хаагчаар томилсон. Тайлант хугацаанд Дорноговь аймаг дахь газар, Баруун бүс дэх газарт дээрх чиг үүргийг хариуцан ажиллаж байгаад ажлаас чөлөөлөгдсөн болон нэгж хооронд шилжин томилогдсон албан хаагчийн оронд харьяа нэгжийн саналыг үндэслэн байгууллагын даргын А/467 дугаар тушаалаар 2 албан хаагчийг нөхөн томилон ажиллуулж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг мөрдөх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагад үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилгоор 4 асуулт бүхий асуумжийг 02 болон 11 дүгээр сард авч, нийт 213 албан хаагчийг хамруулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хүрээнд албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил, дутагдлыг давтан гаргахаас сэргийлэх зорилгоор байгууллагын даргын 03 дугаар сарын 11-ний өдрийн А/118 дугаар тушаалаар батлуулсан удирдамжийн дагуу Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд 03 дугаар сарын 31-ний өдөр Агаарын замын боомт хариуцсан газарт, 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 10-ны өдрүүдэд Дорноговь аймаг дахь газарт тус тус ажиллаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албаны чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар хамтарсан уулзалт зохион байгууллаа. Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан "Хүндэлье, энэрье" 1 сарын аяныг байгууллагын хэмжээнд зохион байгууллаа. Аяны хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг таниулах, бие биедээ хүндэтгэлтэй хандах зурагт постер 3, эелдэг найрсаг харилцааг бий болгох арга хэмжээг богино хэмжээний видео шторкоор бэлтгэн, талархлын захидлын хайрцаг аялуулсан. Байгууллагын Immigration.gov.mn цахим хуудаст Ёс зүйн дэд хорооны цэсийг нээн ажиллуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд сургалт мэдээлэл зохион байгуулсан тухай, ёс зүйн гомдол гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн мэдээг тухай бүр байршууллаа. Ёс зүйн дэд хорооны 2 удаагийн дүгнэлтийг ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд бүртгэж, тайлагнасан. Шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад бүрэн хамруулж, арга зүйн зөвлөгөө, мэдлэг мэдээллээр хангаж ажилладаг бөгөөд хөтөлбөрт ёс зүйн 1 цагийн хичээлийг багтаасан. Байгууллагын даргын 03 дугаар сарын 20-ны өдрийн 01-02/16 дугаар удирдамжаар 03 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд "Шинээр томилогдсон албан

хаагчийг чиглүүлэх сургалт"-ыг зохион байгуулсан бөгөөд сургалтад 14 албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн талаар хичээлийг дэд хорооны дарга Н.Дуламсүрэн орсон. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу МУИС-ийн Олон улсын харилцааны тэнхимийн багш, профессор Ж.Баттогтохтой "Манлайлагчийн ёс зүй", Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн Тэргүүн их хамба ламын Ажлын албаны дарга, гавж Д.Нямсамбуутай "Хувь хүний ёс суртахуун", сэтгэл судлаач Д.Оюунноминтой "Харилцаа, ёс зүй ба бидний хандлага", Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор А.Алтанзултай "Төрийн үнэ цэн, төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлага" сэдэвт сургалтуудыг тус тус хамтран зохион байгууллаа. Түүнчлэн Захиргаа, удирдлагын газрын дарга 10 дугаар сарын 10-ны өдөр нийт албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүй, авлига ашиг сонирхлын зөрчил" сэдэвт сургалт хийсэн. Зохион байгуулсан 5 удаагийн сургалтад танхим болон цахимаар давхардсан тоогоор 423 албан хаагч хамрагдсан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
1.Албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдол мэдээлэл 2024 оны мөн үетэй харьцуулахад 100 хувь буурсан үзүүлэлттэй байна.	1.Байгууллагын батлагдсан төсөв, санхүүжилт зэрэг үйл ажиллагаанаас хамааарч аливаа сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулахад санхүүгийн бэрхшээл тулгарч байна.

Санал:
1.Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарыг сургалтад хамруулах, сертификат олгох, мэргэшүүлэх 2.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг хийлгэх, холбогдох албан хаагчдыг сургалтад хамруулах

Шалгах хэсэг:

- ☑ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
ДАРГА */Н.УУГАНБАЯР/*

Ёс зүйн дэд хорооны дарга
ЗӨРЧИЛ ШАЛГАН, ШИЙДВЭРЛЭХ ГАЗРЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ */Н.ДУЛАМСҮРЭН/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН */Ш.ДЭМБЭРЭЛДУЛАМ/*

Огноо: 2025 оны 01 сарын 05

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

2026 оны 01 дүгээр сарын 05 Улаанбаатар хот

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлтэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	-	0
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	5
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0.5	5
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0.5	5
Хэсгийн оноо				**4**	**3**	**30**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**9**	**90**

ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

БАТЛАВ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Н.ДУЛАМСҮРЭН

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 01 дүгээр сарын 24

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хариуцах албан тушаалтан, хамтран зохион байгуулах нэгж
1	2	3	4	5
Нэг. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа				
1	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Улирал тутам	- Арга хэмжээний тоо 4	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд
2	Ёс зүй, шударга байдлыг уриалсан цахим зураг хуудас, богино хэмжээний видео бичлэгийг бэлтгэх, хүргэх	Жилдээ	- Цахим зураг хуудас 1; - Мэдээллийн тоо -2	Захиргаа, удирдлагын газар, дэд хорооны нарийн бичгийн дарга, гишүүд
3	Туршилтын хугацаагаар ажилласан албан хаагчтай уулзалт зохион байгуулах, дүгнэлт гаргах	Жилдээ	- Уулзалт сонсголын тоо; - Хамрагдсан албан хаагчийн тоо	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд
4	Хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх талаар уулзалт зохион байгуулах	1, 2 дугаар улиралд	- Уулзалтын тоо; - Хамрагдсан албан хаагчийн тоо	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд Санхүү, хангалт үйлчилгээний газар
5	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаар байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулах	Тухай бүр	- Байршуулсан мэдээллийн тоо	Нарийн бичгийн дарга Мэдээллийн технологийн хэлтэс
6	Байгууллагын хэмжээнд үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх	Эхний хагас жилд	- Дүн шинжилгээний дүн; - Санал, зөвлөмжийн тоо	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд

1	2	3	4	5
7	Удирдах албан тушаалтны цугларалтад оролцох албан хаагчидтай уулзалт зохион байгуулж, санал солилцох	2 дугаар сард	- Хамрагдсан албан хаагчийн тоо	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд
8	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хүрээнд албан хаагчдаас сорил авах	1 дүгээр улиралд	- Хамрагдсан албан хаагчийн тоо	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд
Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх ажиллагаа				
9	Гомдол, мэдээллийг бүртгэх, дэд хорооны даргад танилцуулах	Тухай бүр	- Ирсэн гомдол, мэдээллийн тоо;	Нарийн бичгийн дарга
10	Гомдол, мэдээллийг хянан шалгах ажлыг хуваарилах	Тухай бүр	- Хуваарилсан гомдол, мэдээллийн тоо;	Дэд хорооны дарга
11	Ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэх, мэдээлэх	Тухай бүр	- Хянаж, шалгалтын тоо; - Дүгнэлтийн тоо; - Дотоод сүлжээнд байршуулсан мэдээллийн тоо	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд
12	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг байгууллагын даргад хүргүүлэх	Тухай бүр	- Хүргүүлсэн дүгнэлтийн тоо	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга
13	Шаардлагатай бол холбогдох байгууллага, иргэнд албан бичгээр хариу өгөх	Тухай бүр	- Албан бичгийн тоо	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга
Гурав. Ёс зүйн дэд хорооны дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа				
14	Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийг хөтлөх, холбогдох мэдээллийг бүртгэх	Тухай бүр	- Системд оруулсан мэдээллийн тоо	Нарийн бичгийн дарга
15	Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулах хилийн боомт, орон нутаг дахь нэгжид ажиллах удирдамж боловсруулж, батлуулах	1, 2 дугаар улиралд	- Батлуулсан удирдамжийн тоо	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд
16	Хилийн боомт, орон нутаг дахь нэгжид ажиллах удирдамжийн дагуу ажиллах зардал, сургагч багшийн төлбөр, албан томилолтын зардлын санхүүжилтийг шийдвэрлэх	1, 2 дугаар улиралд	- Шийдвэрлэсэн санхүүжилт	Санхүү, хангалт үйлчилгээний газар
17	Хилийн боомт, орон нутаг дахь нэгжид байгууллагын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээлэл солилцох, уялдаа холбоо, зохицуулалтыг хангах, тайлагнах чиг үүрэг бүхий албан хаагчийг томилон ажиллуулах	1 дүгээр улиралд	- Томилсон албан хаагчийн тоо	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга

1	2	3	4	5
18	Баримт бичгийг хадгаламжийн нэгж үүсгэн, байгууллагын архивд шилжүүлэх	Дараа оны 1 дүгээр сард	- Хадгаламжийн нэгжийн тоо	Нарийн бичгийн дарга
19	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдох мэдээллийг Ёс зүйн хороонд хүргүүлэх	Улирал бүр	- Хүргүүлсэн мэдээллийн тоо	Нарийн бичгийн дарга
20	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Ёс зүйн хороонд хүргүүлэх	Дараа оны 1 дүгээр сард	- Албан бичгийн огноо, дугаар; - Тайлан 1	Нарийн бичгийн дарга

БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО